

“БҮРТГЭЛ-ХАРИУЦЛАГА, ХАМГААЛАЛТ” АЯН

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Бүртгэл-Хариуцлага, хамгаалалт” нөлөөллийн аянд нэгдэж байна.

Гадаадын иргэдийг байрлуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд түүнийг ГИХГ-т 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болох хуулийн зохицуулалттай аж. Энэхүү бүртгэл нь тэднийг хянахаас гадна болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хамгаалах суурь болж байгаа аж.

Гадаадын иргэнийг байрлуулж буй зочид буудал, амралтын газар, аялал жуулчлалын байгууллагуудыг аянд нэгдэж, цахим бүртгэлийн систем e-mongolia.mn, isf.mn сайтыг ашиглан бүртгүүлэхийг уриалж байна.

**“Бүртгэл-Хариуцлага, хамгаалалт”
нөлөөллийн аян**

АЯН 05.26 - 06.13

Та гадаадын иргэнийг орон байраар хангасан бол
48 цагийн дотор бүртгүүлээрэй.

www.immigration.gov.mn +976 - 18001882

ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС